Судлах тэмдэглэл

“Нягт нямбай хөтөлсөн мэдлэг мэдээлэл бол хэрэгтэй үед хэрэглэхэд бэлэн мэдлэг юм. Сүнслэг мэдрэмж бүхий мэдээллийг Их Эзэнтэй холбох ариун нандин газарт, тухайлбал таны эрхэмлэн нандигнадаг тийм газарт хадгалах ёстой. Иймэрхүү туршлага нь таны гэрэл хүлээн авах цаашдын боломжийг нэмэгдүүлдэг.”

Richard G. Scott, “Acquiring Spiritual Knowledge,” *Ensign,* Nov. 1993, 88

АМЬД ХРИСТ

Төлөөлөгчдийн гэрчлэл

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм

Есүс Христ хоёр мянган жилийн өмнө мэндэлснийг бид дурсан тэмдэглэхдээ Түүний зүйрлэшгүй амьдрал, агуу цагаатгач золиослолын хэмжээлшгүй хүч нь үнэн бодитойг гэрчилдэг. Дэлхий дээр амьдарч байсан болон хойшид амьдрах бүх хүнд ийм хүчтэй нөлөөг өөр хэн ч үзүүлэхгүй юм.

Тэр бол Хуучин Гэрээний Агуу Иехова, Шинэ Гэрээний Мессиа билээ. Тэр бол Эцэгийнхээ удирдлаган дор дэлхийг бүтээсэн Бүтээгч. “Бүх юм Түүгээр бий болсон. Бий болсон юмсаас Түүнгүйгээр бий болсон юмс нэг ч байхгүй” (Иохан 1:3). Тэрээр нүгэлгүй байсан ч аливаа зөвт байдлыг гүйцэлдүүлэхийн тулд баптисм хүртэж ад үзэгдсэн ч”сайныг үйлдэж явлаа” (Үйлс 10:38). Түүний сайн мэдээ бол энх амгалан болон сайн санааны захиас байлаа. Тэрээр хүн бүхнийг Өөрийнхөө үлгэр жишээг дагахыг хүсч байлаа. Тэрбээр Палестины замуудаар алхан өвчтэйг эдгээж, хараагүйг хардаг болгон, үхэгсдийг босгож явлаа. Бас мөнхийн үнэнүүд, мөнх бус байдлын өмнөх амьдралд бид оршин амьдарч байсан нь үнэн болохыг, дэлхий дээрх бидний амьдралын зорилго, ирэх амьдрал дахь Бурханы хөвгүүд, охидын өсөн хөгжих боломжуудын тухай заадаг байв.

Тэрбээр ариун ёслолыг Өөрийн агуу цагаатгач золиослолын сануулагч болгон бий болгосон юм. Түүнийг баривчилж, хилс хэрэгт буруутган, хилэгнэсэн олны шаардлагыг биелүүлэхийн тулд Калварид загалмайд дүүжлэн цаазаар авах ял оноосон билээ. Тэрээр бүх хүн төрөлхтний нүглийг цагаатгахын төлөө амиа өгсөн юм. Дэлхий дээр амьдарч байсан, амьдарч байгаа болон амьдрах бүх хүнд Түүний агуу бэлэг зориулагдсан юм.

Бүх хүн төрөлхтний түүхэнд гол суурийг эзэлдэг Түүний амьдрал Бетлехемд эхлэгүй бас Калвари дээр дуусаагүйг бид хүндэтгэлтэйгээр гэрчилж байна. Тэр бол Эцэгийн Уган Хүү, махан биеэр төрсөн Эцэгийн Төрсөн Ганц Хүү, дэлхийн Гэтэлгэгч мөн.

Тэрээр булшнаас босч ирэн, “нойрсогсдоос анхны үр жимс болсон юм” (1 Коринт 15:20). Амилсан Их Эзэн мөнх бус үйлчлэлийнхээ үед хайрладаг байсан хүмүүс дээрээ очжээ. Тэр бас эртний Америк дахь “өөр хонин сүрэг” (Иохан 10:16)-тээ үйлчилсэн юм. Өнөөгийн дэлхийд Тэрбээр Эцэгийнхээ хамт Иосеф Смит хөвгүүн дээр хүрч ирэн, өнө эртнээс амлагдсан “цагийн дүүрнийг” (Ефес 1:10) эхлүүлсэн билээ.

Бошиглогч Иосеф Амьд Христийн тухай “Түүний мэлмий галын дөл лүгээ адил байв; тэргүүнийх нь үс цэвэрхэн цас мэт цав цагаан байв; түүний төрх байдал нарны гэрлээс ч илүү хурцаар гялалзаж байлаа; мөн дуу хоолой нь агуу их үс хүйлрах мэт байв, бүр Иеховагийн дуу хоолой өгүүлэн;

Бибээр эхнийх мөн эцсийнх болой; Бибээр амьдардаг тэрээр болой, би бол алагдсан тэрбээр бөлгөө; бибээр Эцэгийн өмнө та нарын өмгөөлөгч билээ” (С ба Г 110:3–4) хэмээн бичжээ.

Бошиглогч бас Түүний тухай “Мөн эдүгээ түүний талаар өгөгдсөн олон гэрчлэлийн дараа, энэ бол түүний талаар бидний өгөх хамгийн сүүлчийн гэрчлэл юм: Тэр амьд бөлгөө!

Учир нь бид түүнийг бүр Бурханы баруун гар талд харсан билээ; түүнчлэн тэрээр Эцэгийн Төрсөн Ганц болой хэмээн гэрчлэх дуу хоолойг бид сонссон билээ.

Ийнхүү түүгээр, мөн түүгээр дамжин, мөн түүнээс дэлхийнүүд бүтээгдсэн мөн бүтээгддэг ажгуу, мөн тэдгээрийн оршин суугчид нь Бурханы төрсөн хөвгүүд хийгээд охид нь бөлгөө” (С ба Г 76:22–24) гэж тунхагласан юм.

“Элч нар болон эш үзүүлэгчдийн . . . суурин дээр босгогдсон бөгөөд Есүс Христ Өөрөө булангийн чулуу нь болох” (Ефес 2:20) Түүний санваар, Түүний Сүм дэлхий дээр сэргээгдсэнийг бид хариуцлагатайгаар, хүндэтгэлтэйгээр тунхаглаж байна.

Тэрбээр нэгэн өдөр дэлхий дээр эргэж ирэх болно гэдгийг бид гэрчилж байна. “Дараа нь ЭЗЭНий алдар илэрхийлэгдэж, бүх махан бие хамтдаа үзнэ” (Исаиа 40:5). Тэрээр Хаадын Хаан, Эздийн Эзэн болж захиран хаанчлах бөгөөд Түүний өмнө өвдөг бүхэн сөхөрч мөн хэл бүхэн хүлээн зөвшөөрөн Түүнийг шүтэн бишрэх болно. Бид бүгд өөрсдийн үйлс, зүрх сэтгэлийнхээ хүслээр шүүгдэхийн учир Бурханы өмнө зогсох болно.

Бид зохих ёсоор томилогдсон Түүний Төлөөлөгчдийн хувьд Есүс бол Христ, Бурханы үхэшгүй Хүү гэдгийг гэрчилж байна. Тэр бол өнөөдөр Эцэгийнхээ баруун гар талд байгаа аугаа Иммануел Хаан мөн. Тэр бол дэлхийн гэрэл хийгээд амь амьдрал, иттэл найдвар болой. Түүний зам бол энэ дэлхийд аз жаргал хийгээд ирэх дэлхийд мөнх амьдрал өгд хөтөлдөг зам мөн. Юутай ч зүйрлэшгүй бэлэг болох тэнгэрлэг Хүүгийнх нь төлөө Бурханд талархал өргөе.

ТЭРГҮҮН ЗӨВЛӨЛ



2000 оны 1-р сарын 1

АРВАНХОЁРЫН ЧУУЛГА





Төгс эзэмших сургаалын оршил

Мормоны Номонд бошиглогч Хиламан: “Бурханы Хүү, Христ болох, бидний Гэтэлгэгчийн хадан дээр та нар сууриа тавих ёстойг санагтун” (Хиламан 5:12) хэмээн хөвгүүддээ заасан. Есүс Христ дээр сууриа тавих гэдэгт Түүний сургаалыг ойлгон, итгэж, тэдгээрийн дагуу амьдрах явдал орох бөгөөд эдгээр нь илүү гүн хөрвөгдөн, шавийн хувьд хүлээсэн үүргийнхээ талаарх ойлголтыг гүнзгийрүүлж, дайсны нөлөөнөөс өөрсдийгөө хамгаалан, бусдын амьдралыг адислахад бидэнд тусална.

Үүнийг хэрэгжүүлэх нэг арга зам бол судрыг ангиараа дэс дараатай хамтран судлах явдал юм. Есүс Христэд болон Түүний сургаалд суурилах өөр нэг арга зам бол Төгс эзэмших сургаал хөтөлбөр юм.

Төгс эзэмших сургаалыг судалснаар дараах хоёр үр дүнд хүрнэ.

1. Сүнслэг мэдлэг олж авахад туслах тэнгэрлэг зарчмуудад суралцаж, амьдралдаа хэрэгжүүлэх нь

   Тэнгэрлэг Эцэг сүнслэг мэдлэг олж авах зарчмуудыг илчилсэн. Эдгээр зарчимд итгэлээр үйлдэх, утга санаа болон асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судлах, илүү гүн ойлголтыг тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан эрэлхийлэх зэрэг нь орно. Бид эдгээр зарчмыг амьдралдаа хэрэгжүүлж, сургаал ба түүхэн нөхцөл байдалтай холбоотой асуултыг Есүс Христэд болон Түүний сургаалд итгэх итгэлийг хүчирхэгжүүлдэг Ариун Сүнсийг урин авчрах арга замаар эрэлхийлбэл сургаалыг төгс эзэмших чадварыг хөгжүүлнэ.

2. Есүс Христийн сайн мэдээний сургаал болон сургаалыг зааж буй судрын хэсгийг төгс эзэмших нь

Төгс эзэмших сургаалын энэ үр дүнд дараах байдлаар хүрэх боломжтой.

а. Сургаалын дараах 9 сэдвийн талаар илүү гүн гүнзгий ойлголт олж ав. Тухайлбал:

- Бурхан Тэргүүтэн
- Авралын төлөвлөгөө
- Есүс Христийн Цагаатгал
- Сэргээлт
- Бошиглогчид ба илчлэлт
- Санваар ба санваарын түлхүүрүүд
- Ёслолууд ба гэрээнүүд
- Гэрлэлт ба гэр бүл
- Зарлигууд

б. Энэ материалын “Сүнслэг мэдлэг олж авах нь” хэсэгт болон сургаалын 9 сэдэв бүрд тодорхойлсон сургаалын түлхүүр мэдэгдлүүдийг ойлго.

в. Сургаалын түлхүүр мэдэгдлүүд төгс эзэмших сургаалын судрын хэсэгт хэрхэн заадгийг мэдэж авах, тэдгээр хэсгийг санах, байгаа газрыг нь олж сур.

г. Сургаалын түлхүүр мэдэгдэл тус бүрийг холбогдох төгс эзэмших сургаалын судрын хэсгүүдийг ашиглан тодорхой тайлбарла.

д. Есүс Христийн сайн мэдээний сургаалыг өдөр тутам сонголт хийхдээ мөн сургаал, нийгэм, түүхэн асуудал, асуултад хариулахдаа ашигла.

Сүнслэг мэдлэг олж авах нь

Бурхан бүх үнэний эх сурвалж мөн

1. Бурхан бүхнийг мэддэг бөгөөд бүх үнэний эх сурвалж мөн (Мозая 4:9-ийг үзнэ үү). Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай бөгөөд Өөртэй нь адил болж өсөж хөгжөөсэй гэж хүсдэг учраас биднийг “судлахаар мөн тэрчлэн итгэлээр суралцахыг эрэлхийлэхэд” (С ба Г 88:118) урамшуулан дэмждэг. Бид үнэнийг эрэлхийлэхдээ Бурханы мэргэн ухаан, хайранд болон бидэнд зааж, биднийг адислах хүч чадалд найдсанаар Түүнд бүрэн дүүрэн итгэж болно. Хэрэв бид Бурханыг хичээнгүйлэн эрэлхийлэх юм бол Тэрээр үнэнийг бидний оюун санаа, зүрх сэтгэлд Ариун Сүнсээр дамжуулан илчилнэ хэмээн амласан байдаг (С ба Г 8:2–3-ыг үзнэ үү).

2. Тэнгэрлэг Эцэг бидэнд туслахын тулд сүнслэг мэдлэг хэрхэн олж авахыг заасан. Тэрээр уг мэдлэгийг олж авахын тулд бидний дагах ёстой нөхцөлийг өгсөн. Түүний бурханлаг загвар нь биднээс үнэнийг мэдэх гэсэн чин сэтгэлтэй (Моронай 10:4–5-ыг үзнэ үү) мөн Бурханы илчилсэн зүйлийн дагуу амьдрах хүсэлтэй байхыг шаарддаг (Иохан 7:17-г үзнэ үү). Чин сэтгэлийн хүсэл нь биднийг залбирлаар дамжуулан үнэнийг эрэлхийлэхэд (Иаков 1:5–6; 2 Нифай 32:8–9-ийг үзнэ үү), мөн Бурханы үгийг нухацтай судлахад хөтлөх болно (2 Тимот 3:15–17; 2 Нифай 32:3-ыг үзнэ үү).

Асуулт тавьж, хариулт эрэлхийлэх нь

3. Зарим үед бидэнд Сүмийн сургаал, зан үйл эсвэл түүхийн талаар ойлгоход бэрх шинэ мэдээлэл, асуулт гарч ирж болно. Асуулт тавьж, хариулт эрэлхийлэх нь үнэнийг мэдэхийн тулд гаргах бидний хүчин чармайлтын амин чухал хэсэг юм. Бидний оюун ухаанд орж ирдэг зарим асуулт Ариун Сүнсээр өдөөгдсөн байж болно. Сүнсээр

өдөөгдсөн асуултыг бидний ойлголтыг өсгөн нэмэгдүүлдэг мөн Их Эзэн бидэнд заах хүсэлтэй гэсэн итгэлийг хүчирхэгжүүлэх боломжийг олгодог Бурханы бэлэг хэмээн үзэх нь зүйтэй. Асуулт ямар эх сурвалжаас гарсан эсэхээс үл хамааран бид бодох, эргэцүүлэх, оюун ухаан тэлэх, ойлголтыг маань гүнзгийрүүлэх Их Эзэний нөлөөллийг хүлээн авах чадвараар адислагдсан. Асуулт тавьж, хариулт эрэлхийлж буй хандлага, зорилго нь Ариун Сүнсээр дамжуулан суралцах бидний чадварт ихээхэн нөлөөлнө.

4. Биднийг мөнхийн үнэнийг олж мэдэж, ойлгон, асуулт эсвэл асуудал шийдвэрлэхээр эрэлхийлэх үед дараах гурван зарчим биднийг удирдан чиглүүлэх болно. Тухайлбал:

- Итгэлээр үйлд.
- Утга санаа, асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судал.
- Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү гүн ойлголттой болохыг эрэлхийл.

1-р зарчим: Итгэлээр үйлд

5. Бид Бурханд итгэхийг сонгож мөн эхлээд Түүнд хандан чин сэтгэлээсээ залбирч, сургаалаас суралцан, зарлигуудад нь дуулгавартай байснаар итгэлийнхээ дагуу үйлддэг.

6. Бид ойлголтоо хөгжүүлж, асуудлыг шийдвэрлэхээр эрэлхийлж байхдаа Есүс Христ, Түүний сайн мэдээний сэргээлт болон томилогдсон бошиглогчдынх нь сургаалын талаар аль хэдийн бий болсон гэрчлэл дээрээ тулгуурлах нь зүйтэй. Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд: “Ийм зүйл тохиолдон, асуудал үүсэж, яаж шийдвэрлэгдэх нь тодорхой бус байх үед *олж авсан итгэлээсээ зууран, илүү их мэдлэг олж автал тэвчээртэй байцгаа*” гэж заасан (“Эзэн минь, би итгэж байна,” *Ensign,* 2013 оны 5-р сар, 94 эсвэл *2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 109). Их Эзэн биднийг “Санаа бодол болгондоо над уруу харагтун; бүү эргэлз, бүү ай” (С ба Г 6:36) хэмээн уриасан.

7. Тэр даруй асуултынхаа хариултыг олох боломжгүй үед Тэнгэрлэг Эцэг бидний авралд шаардагдах бүх зүйлийг илчилсэн ч бүх үнэнийг хараахан илчлээгүй байгаа гэдгийг санаж байх нь тустай. Бид хариултыг үргэлжлүүлэн эрэлхийлэхдээ хэзээ нэгэн цагт хариултаа олно гэдэгт найдан, итгэлтэй амьдрах ёстой (Сургаалт үгс 3:5–6; Ифер 12:6-г үзнэ үү). Бид аль хэдийн хүлээн авсан үнэн болон гэрэлд итгэлтэй байх юм бол илүү ихийг хүлээн авна. Бидний асуулт болон залбирлын хариулт ихэвчлэн “шат шатаар, дүрэм дүрмээр” (2 Нифай 28:30) өгөгддөг.

2-р зарчим: Утга санаа болон асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судал

8. Бид сургаалын утга санаа, асуулт, нийгмийн асуудлыг мөнхийн талаас нь шинжлэн судлахдаа тэдгээрийг авралын төлөвлөгөө, Аврагчийн сургаалын хам сэдэв дотор авч үзэх хэрэгтэй. Бид аливаа зүйлийг Их Эзэний мэлмийгээр харахын тулд Ариун Сүнснээс тусламж эрэлхийлдэг (1 Коринт 2:5, 9–11-ийг үзнэ үү). Энэ нь бидэнд дэлхийн таамаглал, ойлголтыг хүлээн авахын оронд асуултыг дахин боловсруулж (асуултыг өөр өнцгөөс харж), үзэл санааг Их Эзэний үнэний жишигт тулгуурлан харах боломжийг олгодог. Бид “Би Тэнгэрлэг Эцэг, Түүний төлөвлөгөө болон хүүхдүүдтэйгээ хэрхэн харилцдаг талаар юуг аль хэдийн мэдэж байгаа вэ?,” “Сайн мэдээний ямар сургаал энэ утга санаа, асуудалтай холбоотой эсвэл тэдгээрийг тодорхойлдог вэ?” гэх мэт асуултыг тавьж болно.

9. Түүхэн үйл явдалтай холбоотой асуултыг ч гэсэн мөнхийн талаас нь шинжлэн судлах хэрэгтэй байж болно. Бид Тэнгэрлэг Эцэг, Түүний авралын төлөвлөгөөнд итгэх итгэл дээр зангуугаа тавьсан хэвээр байж чадвал асуудлыг илүү тодорхой харах боломжтой. Түүнээс гадна, түүхтэй холбоотой асуултыг орчин үеийн үзэл бодол, хандлагыг тулгалгүйгээр тухайн үеийн соёл, жишгийг харгалзаж үзэн, зохих түүхэн хүрээнд нь шинжлэн судлах нь тустай байж болно.

10. Түүхэн баримтууд нь ёслол, гэрээ, сургаалын аврах хүч чадлын талаар өгүүлдэггүй гэдгийг санах нь чухал. Сэргээлтийн гайхамшгийг нээж илрүүлэхийн оронд ач холбогдолгүй зүйлд анхаарлаа хандуулах нь хайрцган доторх гайхалтай бэлгийг үзэлгүй зөвхөн хайрцгийг нь сонирхохтой адил юм.

3-р зарчим: Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү их ойлголт олж авахаар эрэлхийл

11. Их Эзэнээс тогтоосон сүнслэг мэдлэг олж авах үйл явцын нэг хэсэг болгон, Тэрээр үнэн ба удирдамжийг Өөрийн хүүхдүүдэд илчлэх эх сурвалжийг бий болгосон. Эдгээр эх сурвалж бол Христийн гэрэл, Ариун Сүнс, судар, эх эцэг болон Сүмийн удирдагчид юм. Тэргүүн Зөвлөл ба Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга нь өнөө үеийн дэлхий дээрх Их Эзэний бошиглогчид бөгөөд үнэний амин чухал эх сурвалж мөн. Их Эзэн тэднийг Өөртэйгөө ярилцуулах зорилгоор сонгон, томилсон.

12. Түүнээс гадна, бид үнэнийг бусад найдвартай эх сурвалжаас судлах боломжтой. Гэхдээ үнэнийг чин сэтгэлээсээ эрэлхийлэгчид найдваргүй эх сурвалжаас болгоомжилбол зохино. Бид олон хүн “Муух сайн, сайныг муу гэж” (Исаиа 5:20) нэрлэж буй цаг үед амьдарч байна. Сатан бол худал хуурмагийн эцэг бөгөөд үнэнийг мушгин гуйвуулж, биднийг Их Эзэн, Түүний томилсон үйлчлэгчдээс нүүр буруулахад ятгахыг эрэлхийлдэг. Бид Их Эзэний тэнгэрээс томилогдсон эх сурвалжид хариулт, удирдамж авахаар хандвал үнэн, бурууг ялган таних чадвараар адислагдана. Найдваргүй эх сурвалжийг таньж мэдэн, зайлсхийж сурах нь биднийг буруу ташаа мэдээллээс болон итгэлийг устгахыг эрэлхийлэгчдээс хамгаална.

Бусдад сүнслэг мэдлэг олж авахад туслах

13. Хүмүүс Сүмийн сургаал, зан үйл, түүхийн талаар асууж, сонирхон ирэх үед бид тэдний үнэнийг эрэлхийлж буй эрэл хайгуулд хэрхэн хамгийн сайнаараа тусалж болох вэ? Бид дараах арга замаар тэдэнд туслах боломжтой. Тухайлбал:

14. *Анхааралтай бөгөөд залбиран байж сонс.* Тэдний жинхэнэ асуултад хариулахын өмнө анхааралтай сонсож, тодруулж, ойлгохыг эрэлхийл. Асуултынх нь үнэн зорилго, мэдрэмж, итгэл үнэмшлийг ойлгохын тулд нухацтай эрж хай.

15. *Сайн мэдээний үнэнийг зааж, гэрчил.* Судрын болон орчин үеийн бошиглогчдын зохих сургаалаас мөн уг сургаал таны амьдралыг хэрхэн өөрчилсөн талаар хуваалц. Ярьж байгаа хүндээ асуултаа сайн мэдээний болон авралын төлөвлөгөөний агуулгын хүрээнд шинжлэн судалж эсвэл өөрчлөн боловсруулахад тусал.

16. *Тэднийг итгэлийнхээ дагуу үйлдэхэд урь.* Их Эзэн биднээс сүнслэг мэдлэгийг өөрсдөө эрэлхийлэхийг шаарддаг гэдгийг сана. Тиймээс бид бусдыг залбирч, зарлигуудад дуулгавартай байхыг болон Бурханы үгийг тууштай судалж, тэнгэрээс томилсон эх сурвалжийг, ялангуяа Мормоны Номыг ашиглах замаар итгэлээр үйлдэхэд урих ёстой. Шаардлагатай бол тэднийг нэмэлт мэдлэг олж авах хүртлээ Ариун Сүнс мэдэрч байсан үеийнхээ туршлагыг эргэн санаж, сурч мэдсэн үнэндээ үнэнч хэвээр үлдэхэд урамшуулан дэмж.

17. *Эхэлсэн ажлаа дуусга.* Хариулт хайж олно гэж амлаад, дараа нь сурч мэдсэн зүйлээ хуваалцах замаар эхэлсэн ажлаа дуусга. Түүнээс гадна хариултыг хамтдаа хайж болно. Хувийн илчлэлт өгнө гэсэн Их Эзэний амлалтад итгэдэг гэдгээ илэрхийл.

Холбогдох эшлэлүүд: Иеремиа 1:4–5; Амос 3:7; Матай 5:14–16; Матай 16:15–19; Иохан 15:16; Иохан 17:3; Ефес 2:19–20; Ефес 4:11–14; 2 Нифай 2:27; Мозая 18:8–10; 3 Нифай 18:15, 20–21; С ба Г 1:37–38; С ба Г 18:15–16; С ба Г 21:4–6; С ба Г 88:118

Холбогдох сургаалын сэдвүүд: Бурхан Тэргүүтэн: Ариун Сүнс; Есүс Христийн Цагаатгал: Есүс Христэд итгэх итгэл; Бошиглогчид ба илчлэлт; Зарлигууд

Сургаалын сэдвүүд

Сургаалын дарааx 9 сэдэвт Есүс Христийн сайн мэдээний суурь үнэнүүд орсон болно. Эдгээр сэдвийн талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг topics.lds.org руу орж, эсвэл *Итгэлдээ үнэнч байх нь: Судрын заалт*-аас үзнэ үү (2004).

1. Бурхан Тэргүүтэн



1.1. Бурхан Тэргүүтэн бол Бурхан Мөнхийн Эцэг, Түүний Хүү Есүс Христ, Ариун Сүнс гэсэн тусдаа гурван биес юм. Эцэг, Хүү хоёр барьж мэдрэгдэх яс, махан өргөмжлөгдсөн биетэй бол Ариун Сүнс нь сүнсэн биетэй (С ба Г 130:22–23-ыг үзнэ үү). Тэд нэг зорилготой бөгөөд Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөг тохиолгон авчрах нэг зорилгын төлөө төгс эв нэгдэлтэй ажилладаг.

Холбогдох эшлэлүүд: Эхлэл 1:26–27; Лук 24:36–39; Иосеф Смит—Түүх 1:15–20

Бурхан Эцэг

1.2. Бурхан Эцэг бол бидний шүтэн биширдэг Аугаа Нэгэн мөн. Тэр бол бидний сүнсний Эцэг (Еврей 12:9-ийг үзнэ үү). Тэрбээр төгс бөгөөд бүхнийг чаддаг мөн мэддэг. Түүнчлэн Тэрээр шударга, энэрэнгүй, нинжин сэтгэлтэй. Бурхан бүх хүүхдээ төгс хайрладаг бөгөөд бид Түүнтэй адил юм (2 Нифай 26:33-ыг үзнэ үү). Түүний ажил ба алдар суу нь үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах явдал билээ.

Холбогдох эшлэлүүд: Иохан 17:3; Мозая 4:9; Мосе 1:39

Есүс Христ

1.3. Есүс Христ бол сүнсээр төрсөн Эцэгийн Уган Хүү, махан биеэр төрсөн Эцэгийн Төрсөн Ганц билээ. Есүс Христ Эцэгийн удирдлаган доор тэнгэр болон газрыг бүтээсэн. Тэр бол Хуучин Гэрээний Иехова, Шинэ Гэрээний Мессиа мөн.

1.4. Есүс Христ бүх зүйлийг Эцэгийн тааллаар хийдэг. Тэр нүгэлгүй амьдралаар амьдарсан ба бүх хүн төрөлхтний нүглийг цагаатгасан (3 Нифай 11:10–11-ийг үзнэ үү). Түүний амьдрал бидэнд хэрхэн амьдрах ёстойг харуулсан төгс үлгэр жишээ мөн (3 Нифай 12:48-ыг үзнэ үү). Тэр бол Тэнгэрлэг Эцэгийн амилсан хүүхдүүдийн анхных нь байсан.

Тэрээр өнөө цагт ч эрт дээр үеийн адил энэ Сүмийг тэргүүлдэг. Тэрээр хүч, алдар суутайгаар дахин ирж, Мянган жилийн турш дэлхий дээр хаанчилна (С ба Г 29:10–11-ийг үзнэ үү). Тэр бүх хүн төрөлхтнийг шүүх болно.

1.5. Есүс Христ бидний Аврагч бөгөөд Эцэгт биднийг зуучилдаг учраас бүх залбирал, адислал, санваарын ёслолууд Түүний нэрээр хийгдэх ёстой (3 Нифай 18:15, 20–21-ийг үзнэ үү).

Холбогдох эшлэлүүд: Исаиа 53:3–5; Лук 24:36–39; 1 Коринт 15:20–22; Илчлэлт 20:12; Алма 7:11–13; Алма 34:9–10; Хиламан 5:12; Моронай 7:45, 47–48; С ба Г 1:30; С ба Г 6:36; С ба Г 18:10–11; С ба Г 19:16–19; С ба Г 76:22–24

Холбогдох сэдэв: Есүс Христийн Цагаатгал

Ариун Сүнс

1.6. Ариун Сүнс бол Бурхан Тэргүүтэний гурав дахь гишүүн юм. Тэр сүнсэн биетэй учраас яс, махан биегүй. Түүнийг ихэвчлэн Сүнс, Ариун Сүнс, Бурханы Сүнс, Их Эзэний Сүнс эсвэл Тайтгаруулагч гэж нэрлэдэг.

1.7. Ариун Сүнс Эцэг, Хүү хоёрыг гэрчилж, бүх зүйлийн үнэнийг илчилдэг ба наманчилж, баптисм хүртсэн хүмүүсийг ариусгадаг. Бид Ариун Сүнсний хүчээр дамжуулан бидний сайн сайхны төлөө төдийгүй бусдад үйлчлэн, адислахад туслах адислал, чадваруудыг буюу сүнсний бэлгүүдийг хүлээн авах боломжтой.

Холбогдох эшлэлүүд: Иохан 3:5; 1 Коринт 2:5, 9–11; 2 Нифай 32:3; 2 Нифай 32:8–9; Мозая 3:19; Мозая 18:8–10; 3 Нифай 27:20; Моронай 7:45, 47–48; Моронай 10:4–5; С ба Г 8:2–3; С ба Г 130:22–23

Холбогдох сэдвүүд: Сүнслэг мэдлэг олж авах нь; Ёслолууд ба гэрээнүүд

2. Авралын төлөвлөгөө

2.1. Мөнх бус оршихуйн өмнөх амьдралд Тэнгэрлэг Эцэг бидэнд Өөртэй нь адилхан болж, үхэшгүй байдал, мөнх амьдралтай болох боломж олгох нэгэн төлөвлөгөөг танилцуулсан юм (Мосе 1:39-ийг үзнэ үү). Бид энэ төлөвлөгөөг биелүүлэн, Тэнгэрлэг Эцэгтэйгээ адилхан болохын тулд Түүнийг болон Түүний Хүү Есүс Христийг таньж мэдэн, Тэдний зан байдал, шинж чанарын талаар зөв ойлголттой байх ёстой (Иохан 17:3-ыг үзнэ үү).

2.2. Судрууд Тэнгэрлэг Эцэгийн энэ төлөвлөгөөг “авралын төлөвлөгөө,” “аз жаргалын агуу төлөвлөгөө,” “нигүүлслийн төлөвлөгөө” гэж нэрлэдэг. Энэ төлөвлөгөөнд Бүтээлт, Уналт, Есүс Христийн Цагаатгал, сайн мэдээний бүх хууль, ёслол, сургаал багтдаг. Ёс суртахууны сонгох эрх буюу өөрсдөө сонгож, үйлдэх чадвар нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний бас нэгэн чухал хэсэг юм. Бидний мөнхийн өсөлт хөгжил энэ бэлгээ хэрхэн ашиглахаас шалтгаална (Иошуа 24:15; 2 Нифай 2:27-г үзнэ үү).

2.3. Есүс Христ Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөний төвд байдаг. Авралын төлөвлөгөө нь бидэнд төгс төгөлдөр болж, бүрэн дүүрэн баяр баясгаланг хүлээн авч, гэр бүлийн харилцаа холбоогоо мөнхөд авч үлдэн, Бурхантай үүрд хамт амьдрах боломж олгодог.

Холбогдох эшлэлүүд: Malachi 4:5–6; 3 Nephi 12:48; C ба Г 131:1–4

Мөнх бус байдлын өмнөх амьдрал

2.4. Бид дэлхий дээр төрөхөөсөө өмнө Тэнгэрлэг Эцэгийнхээ дэргэд Түүний сүнсэн хүүхдүүдийн хувиар амьдарч байсан (Абрахам 3:22–23-ыг үзнэ үү). Бид энэхүү мөнх бус байдлын өмнөх оршихуйд Тэнгэрлэг Эцэгийн бусад сүнсэн хүүхэдтэй хамт тэнгэрт болсон зөвлөгөөнд оролцсон юм. Уг зөвлөгөөн дээр Тэнгэрлэг Эцэг Өөрийн төлөвлөгөөг танилцуулсан ба мөнх бус байдлын

өмнөх амьдралд байсан Есүс Христ Аврагч болохоор гэрээ байгуулсан билээ.

2.5. Бид сонгох эрхээ ашиглан Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг дагахаар болсон. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг дагасан хүмүүст дэлхий дээр ирж, мөнх бус амьдралдаа туршлага хуримтлуулан, өсөж хөгжих, улмаар мөнх амьдралд хүрэх боломжийг олгосон юм. Бурханы өөр нэгэн сүнсэн хүү Люсифер авралын төлөвлөгөөг эсэргүүцэн, бослого гаргасан. Тэрээр Сатан болж, дагалдагчдынхаа хамт тэнгэрээс хөөгдсөнөөр бие махбодтой болох, мөнх бус амьдралаар амьдрах онцгой эрхээ алджээ.

Холбогдох эшлэлүүд: Иеремиа 1:4–5; Еврей 12:9; 2 Нифай 2:27; 3 Нифай 11:10–11

Бүтээлт

2.6. Есүс Христ Эцэгийн удирдлаган доор тэнгэр ба газрыг бүтээсэн (С ба Г 76:22–24-ийг үзнэ үү). Дэлхийг бүтээх нь Бурханы төлөвлөгөөнд зайлшгүй чухал байв. Дэлхий бол бие махбодтой болж, соригдон, бурханлаг зан төлөвийг хөгжүүлэх газар юм.

2.7. Адам бол дэлхий дээр бүтээгдсэн анхны хүн. Бурхан Адам, Ева хоёрыг Өөрийн дүр төрхөөр бүтээсэн. Бүх хүн төрөлхтөн—эрэгтэй мөн эмэгтэй—бүгд Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн (Эхлэл 1:26–27-г үзнэ үү). Хүйс бол хувь хүн бүрийн мөнх бус байдлын өмнөх, мөнх бус болон мөнх амьдрал дахь мөн чанар, зорилгын онцлог шинж нь юм.

Уналт

2.8. Едений цэцэрлэгт Бурхан Адам, Ева хоёрыг гэрлэлтээр холбосон. Адам, Ева хоёр цэцэрлэгт байхдаа Бурханы хажууд тэр хэвээрээ, мөнхөд амьдрах боломжтой байв. Тэд цэвэр ариун байсан бөгөөд Бурхан тэдний хэрэгцээг хангаж байлаа.

2.9. Адам, Ева хоёрыг Едений цэцэрлэгт байхад Бурхан тэдэнд сонгох боломж олгосон. Тэр тэдэнд сайн, муугийн мэдлэгийн модны жимс болох хориглогдсон жимснээс бүү ид хэмээн зарлигласан билээ. Энэ зарлигийг дагавал тэд цэцэрлэгт үлдэх байв. Гэхдээ Адам, Ева хоёр цэцэрлэгт үлдэх юм бол мөнх бус амьдрал дахь эсрэг тэсрэг байдлыг биеэрээ туулж, өсөж хөгжихгүй гэдгээ хараахан мэдэхгүй байлаа. Тэд уй гашуу, өвчин шаналлыг үзэхгүй учраас баяр баясгалан гэж юу болохыг ч мэдэж боломжгүй байв. Цаашилбал, тэд хүүхдүүдтэй болж чадахгүй байх байсан.

2.10. Сатан Адам, Ева хоёрыг хориглосон жимсийг ид хэмээн уруу татахад тэд идэх сонголтыг хийсэн. Тэд ийм сонголт хийсэн учраас Бурханы оршихуйгаас хөөгдөж, унасан бөгөөд мөнх бус болсон юм. Адам, Ева хоёрын зөрчил болон үүнээс үүдэлтэй өөрчлөлтүүд, тухайлбал сүнсний болон биеийн үхлийг Уналт хэмээн нэрлэдэг. Сүнсний үхэл нь Бурханаас тусгаарлагдах явдал юм. Биеийн үхэл нь мөнх бус биеэс сүнс салах үйл явц мөн.

2.11. Уналт бол Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөний амин чухал хэсэг. Уналтын үр дүнд Адам, Ева хоёр үр хүүхэдтэй болох боломжтой болсон. Тэд үр удмаараа баяр баясгалан, уй гашууг биеэрээ туулж, муугаас сайныг ялган таньдаг болж, өсөж хөгжих боломжтой болсон юм (2 Нифай 2:22–25-ыг үзнэ үү).

2.12. Бид Адам, Ева хоёрын үр удмын хувьд мөнх бус амьдралдаа уналтын нөхцөл байдлыг өвлөн авсан. Бид Бурханаас тусгаарлагдан, биеийн үхэлд захирагддаг болсон. Түүнээс гадна, бид мөнх бус амьдралын хүнд хэцүү зүйлс болон дайсны уруу таталтаар соригдог. Хэдийгээр бид Адам, Ева хоёрын зөрчлийн үр дагаврыг үүрэхгүй ч өөрсдийн нүглийн үр дагаврыг хариуцах ёстой. Бид Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан Уналтын сөрөг үр дагаврыг ялан дийлж, нүглийнхээ өршөөлийг хүлээн авч, эцэст нь баяр баясгалангийн бүрэн байдлыг мэдрэх боломжтой.

Холбогдох эшлэлүүд: Эхлэл 1:28; Мозая 3:19; Алма 34:9–10

Холбогдох сэдэв: Есүс Христийн Цагаатгал

Мөнх бус амьдрал

2.13. Мөнх бус амьдрал нь сонгох эрхээ ашиглан Их Эзэний зарлигласан бүх зүйлийг хийнэ гэдгээ нотолж, бурханлаг зан чанарыг хөгжүүлснээр өөрсдийгөө мөнх амьдралд бэлтгэх мөн суралцах хугацаа юм. Бид үүнийг Есүс Христ, Түүний Цагаатгалд итгэх итгэлээ хөгжүүлэн, наманчлал, баптисм, гишүүний баталгаа гэх мэт авралын ёслол ба гэрээнүүдийг хүлээн авч, Есүс Христийн үлгэр жишээг мөнх бус амьдралынхаа эцсийн өдрийг хүртэл итгэлтэй дагаснаар хийдэг.

2.14. Мөнх бус байдалд бидний сүнс бие махбодтой нэгдэн нийлж, бидэнд мөнх бус байдлын өмнөх дэлхийд боломжгүй байсан арга замаар өсөж хөгжих боломжийг олгодог. Тэнгэр дэх Эцэг яс махан, бодит биетэй учраас бидэнд өсөж хөгжин, Түүнтэй адил болоход бие махбод хэрэгтэй. Бидний бие махбод ариун бөгөөд бид Тэнгэрлэг Эцэгийнхээ өгсөн энэ бэлэгт хүндэтгэлтэй хандах ёстой (1 Коринт 6:19–20-ийг үзнэ үү).

Холбогдох эшлэлүүд: Иошуа 24:15; Матай 22:36–39; Иохан 14:15; 2 Нифай 2:27; 3 Нифай 12:48; Моронай 7:45, 47–48; С ба Г 130:22–23

Холбогдох сэдвүүд: Бурхан Тэргүүтэн; Есүс Христийн Цагаатгал; Ёслолууд ба гэрээнүүд; Зарлигууд

Үхлийн дараах амьдрал

2.15. Нас барсны дараа бидний сүнс сүнсний дэлхийд очиж, Амилуулалтыг хүлээнэ. Зөв шударга хүмүүсийн сүнсийг диваажин хэмээн нэрлэдэг аз жаргалын байдалд хүлээн авна. Үнэний талаарх мэдлэггүй нас барсан болон мөнх бус байдалдаа дуулгаваргүй байсан хүмүүс сүнсний дэлхий гэгдэх мөнх бус байдлын дараах түр зуурын байдалд очно.

2.16. Эцсийн эцэст хүн бүрд сайн мэдээний зарчмуудаас суралцан, ёслол ба гэрээнүүдийг хүлээн авах боломж олдох болно. Итгэлтэй олон хүн сүнсний шоронд байгаа хүмүүст сайн мэдээг номлоно. Сайн мэдээг хүлээн авч, наманчилж, өөрсдийнх нь өмнөөс ариун сүмд хийсэн авралын ёслолуудыг хүлээн авсан хүмүүс Амилуулалт хүртэл диваажинд амьдрах юм (1 Петр 4:6-г үзнэ үү).

2.17. Амилуулалт гэж бидний сүнс төгс төгөлдөр мах, ясан биетэйгээ дахин нэгдэхийг хэлнэ. Амилуулалтын дараа бид үхэшгүй мөнх болсон байх бөгөөд бидний сүнс ба бие махбод дахин хэзээ ч салахгүй. Есүс Христ биеийн үхлийг ялан дийлсэн учраас дэлхий дээр төрсөн хүн бүр амилуулагдана (1 Коринт 15:20–22-ыг үзнэ үү). Зөв шударга хүмүүс ёс бусчуудаас өмнө амилуулагдаж, Анхны амилуулалтаар босож ирнэ.

2.18. Амилуулалтын дараа Эцсийн шүүлт болно. Есүс Христ хүн бүрийн хүлээн авах мөнхийн алдар сууг тодорхойлохын тулд тэднийг шүүнэ. Энэхүү шүүлт хүн нэг бүрийн хүсэл, Бурханы зарлигуудад хэр зэрэг дуулгавартай байсан зэрэгт үндэслэх юм (Илчлэлт 20:12-ыг үзнэ үү).

2.19. Алдар суугийн селестиел, террестиел, телестиел хаант улс гэсэн гурван хаант улс байдаг (1 Коринт 15:40–42-ыг үзнэ үү). Есүсийг гэрчлэхдээ зоригтой, сайн мэдээний зарчмуудад дуулгавартай байсан хүмүүс селестиел хаант улсад Бурхан Эцэг ба Түүний Хүү Есүс Христийн оршихуйд, гэр бүлийнхээ зөв шударга гишүүдтэй хамт амьдрах болно.

Холбогдох эшлэлүүд: Лук 24:36–39; Иохан 17:3; С ба Г 131:1–4

Холбогдох сэдвүүд: Есүс Христийн Цагаатгал; Ёслолууд ба гэрээнүүд

3. Есүс Христийн Цагаатгал

3.1. Мөнх бус байдлын өмнөх дэлхийд болсон зөвлөгөөнөөр Есүс Христ бидний Аврагч, Гэтэлгэгч байхаар урьдчилан томилогдсон. Тэр бүх хүн төрөлхтнийг Уналтын сөрөг үр дагавраас гэтэлгэж, бидний гэм нүглийн төлөөсийг төлөхөөр Өөрийн хүслээр зовж шаналан, амиа өгсөн билээ. Есүс Христ зовж шаналан, үхэж мөн амилсны үр дүнд сүнслэг болон бие махбодын үхлийг ялан дийлсэн энэ үйл явдлыг Цагаатгал хэмээн нэрлэдэг. Түүний золиослол бидний хүн нэг бүрд ач тустай бөгөөд Тэнгэрлэг Эцэгийн хүүхэд бүр юу юунаас ч илүү үнэ цэнтэй гэдгийг харуулдаг (С ба Г 18:10–11-ийг үзнэ үү).

3.2. Есүс Христ бүх хүн төрөлхтний төлөө хэмжээлшгүй хийгээд мөнхийн золиослол хийж чадах цорын ганц хүн байсан учраас бид зөвхөн Түүгээр дамжуулан аврагдах боломжтой (Алма 34:9–10-ыг үзнэ үү). Зөвхөн Түүнд бие махбодын үхлийг ялан дийлэх хүч байсан. Тэрээр мөнх бус эх Мариагаасаа үхэх чадварыг өвлөн авсан бол Өөрийн мөнхийн Эцэг Бурханаас үүрд мөнх амьдрах буюу Өөрийн амийг өгч, дахин хүлээн авах хүчийг өвлөн авсан юм. Тэр л ганцаараа биднийг гэм нүглээс гэтэлгэж чадах байв. Тэрээр төгс, нүгэлгүй амьдралаар амьдарсан учраас шударга ёсны шаардлагаас чөлөөлөгдөж, нүглээ наманчилсан хүмүүсийн өрийг төлөх боломжтой байсан.

3.3. Түүний Цагаатгалд хүн төрөлхтний нүглийн төлөө Гетсеманийн цэцэрлэгт үүрсэн зовлон, урсгасан цус, загалмай дээрх шаналал болон үхэл мөн булшнаас гарч ирсэн зэрэг нь багтдаг. Есүс бол амилуулагдсан анхны хүн байсан. Тэр булшнаасаа өргөмжлөгдөн, мөнхийн мах, ясан биетэйгээр боссон билээ (Лук 24:36–39-ийг үзнэ үү). Түүний Цагаатгалын ачаар бүх хүн төрөлхтөн төгс, мөнх бие махбодтойгоор амилуулагдан, Бурханы оршихуйд шүүгдэхээр аваачигдах болно. Есүс Христийн цагаатгагч золиослол нь Бурханы оршихуйд мөнхөд амьдрах боломжийг бидэнд

олгохын тулд гэм нүглээсээ цэвэршин, өршөөгдөх цорын ганц арга замыг өгсөн билээ (Исаиа 1:18; С ба Г 19:16–19-ийг үзнэ үү).

3.4. Есүс Христ Цагаатгалын нэгэн хэсэг болохын хувьд бидний нүглийн төлөө зовж шаналаад зогсохгүй, бүх хүн төрөлхтний өвчин шаналал, уруу таталт, өвчин эмгэг, сул дорой байдлыг Өөртөө авсан (Исаиа 53:3–5; Алма 7:11–13-ыг үзнэ үү). Тэрээр өөрийн биеэр зовлонг амсаж туулсан учраас бидний зовлонг ойлгодог. Бид Аврагчид итгэн, Түүн дээр ирвэл Тэр биднийг ачаагаа үүрэхэд мөн өөрсдийн хүчээр хийж чадахгүй зүйлсээ хийхэд хүчирхэгжүүлэх болно (Матай 11:28–30; Ифер 12:27-г үзнэ үү).

3.5. Есүс Христ бидний нүглийн төлөөсийг төлснөөр хувийн үүрэг хариуцлагаас маань чөлөөлж байна гэсэн үг биш юм. Бид Түүний золиослолыг хүлээн авч, нүглээсээ цэвэршин, мөнх амьдралыг өвлөн авахын тулд Түүнд итгэх итгэлээ хөгжүүлэн, наманчилж, баптисм хүртэж, Ариун Сүнсийг хүлээн авч, амьдралынхаа эцсийн өдрийг хүртэл тэвчвэл зохино.

Холбогдох эшлэлүүд: Иохан 3:5; 1 Коринт 15:20–22; Мозая 3:19; 3 Нифай 11:10–11; 3 Нифай 27:20; С ба Г 76:22–24

Холбогдох сэдвүүд: Бурхан Тэргүүтэн: Есүс Христ; Авралын төлөвлөгөө: Уналт; Ёслолууд ба гэрээнүүд

Есүс Христэд итгэх итгэл

3.6. Сайн мэдээний анхны зарчим бол Их Эзэн Есүс Христэд итгэх явдал мөн. Бидний итгэл Есүс Христ дээр төвлөрсөн цагт энэхүү итгэл биднийг аврал өөд хөтөлнө (Хиламан 5:12-ыг үзнэ үү).

3.7. Есүс Христэд итгэх итгэлд Түүнийг Бурханы Төрсөн Ганц Хүү, дэлхийн Аврагч гэдэгт бат итгэх итгэл орно. Бид Бурханы Хүүгийн хэмжээлшгүй Цагаатгалд итгэж мөн Есүс Христэд найдаж, Түүний сургаалыг дагах нь Тэнгэрлэг Эцэгтэйгээ эргэн амьдрах цорын ганц боломж гэдгийг мэднэ. Итгэл бол идэвхгүй сүсэг бишрэл биш бөгөөд Есүс Христэд итгэх жинхэнэ итгэл амьдралын маань хэв маягаар илэрдэг (Иаков 2:17–18-ыг үзнэ үү). Бид залбирч, судраас судалж, Бурханы зарлигуудад дуулгавартай байснаар итгэлээ хөгжүүлэх боломжтой.

Холбогдох эшлэлүүд: Сургаалт үгс 3:5–6; Ифер 12:6; С ба Г 6:36

Холбогдох сэдэв: Сүнслэг мэдлэг олж авах нь

Наманчлал

3.8. Есүс Христэд итгэх итгэл, Түүнийг болон Тэнгэрлэг Эцэгээ хайрлах хайр биднийг наманчлал руу хөтөлдөг. Наманчлал бол сонголтынхоо үр дүнг үүрэх боломжтой бүх хүүхдэдээ зориулсан Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэгэн хэсэг юм. Энэхүү бэлэг Есүс Христийн Цагаатгалаар боломжтой болсон. Наманчлал бол оюун ухаан, зүрх сэтгэлийн өөрчлөлт. Үүнд нүгэл үйлдэхгүй байх, бодол санаа, үйлдэл, хүслээ Бурханд хандуулах, өөрийн хүслийг Түүний хүсэлтэй нийцүүлэх зэрэг нь орно (Мозая 3:19-ийг үзнэ үү).

3.9. Наманчлалд нүглээ хүлээн зөвшөөрөх, нүгэл үйлдсэндээ бурханлаг харууслаар харуусах, Тэнгэрлэг Эцэгтээ мөн шаардлагатай бол бусдад нүгэл үйлдсэнээ хүлээх, нүглээ орхих, нүглийн улмаас учруулсан бүх хохирлыг аль болох бүрэн нөхөн төлөхийг хичээх, Бурханы зарлигуудад дуулгавартай амьдрах зэрэг нь багтдаг (С ба Г 58:42–43-ыг үзнэ үү). Их Эзэн баптисм хүртвэл бидний нүглийг өршөөнө хэмээн амладаг бөгөөд бид Аврагчийг дурсан санаж, Түүний зарлигуудыг дагах чин хүсэлтэйгээр ариун ёслолоос хүртэх бүрдээ уг гэрээг шинэчилдэг.

3.10. Бид чин сэтгэлийн наманчлал ба Есүс Христийн Цагаатгалын ач ивээлээр дамжуулан Бурханы өршөөлийг хүлээн авч, амар амгаланг мэдрэх боломжтой. Бид Сүнсний нөлөөг илүү их мэдэрч, Тэнгэрлэг Эцэгтэй болон Түүний Хүүтэй мөнхөд хамт амьдрахад улам бүр бэлтгэгдэх болно.

Холбогдох эшлэлүүд: Исаиа 1:18; Иохан 14:15; 3 Нифай 27:20; С ба Г 19:16–19

Холбогдох сэдэв: Ёслолууд ба гэрээнүүд

4. Сэргээлт

4.1. Бурхан Өөрийн үнэн, санваарын эрх мэдэл болон Сүмийг дэлхийд дахин сэргээн байгуулснаар Өөрийн сайн мэдээг хожмын өдрүүдэд сэргээсэн. Эртний бошиглогчид хожмын үед тохиох сайн мэдээний сэргээлтийг зөгнөн хэлсэн байдаг (Исаиа 29:13–14; Үйлс 3:19–21-ийг үзнэ үү).

4.2. Сэргээлт 1820 онд эхэлсэн. Бурхан Эцэг, Түүний Хүү Есүс Христ хоёр Иосеф Смитийн залбирлын хариуд түүнд үзэгдсэн бөгөөд түүнийг Сэргээлтийн бошиглогчоор дуудсан (Иосеф Смит—Түүх 1:15–20-ийг үзнэ үү).

4.3. Бурхан Иосеф Смитийг амьд Христийн хожмын үеийн гэрч болгохоор дуудсан билээ. Иосеф Смит Сэргээлтийн бошиглогчийн хувьд Мормоны Номыг Бурханы бэлэг болон хүчээр орчуулсан (С ба Г 135:3-ыг үзнэ үү). Библи нь Мормоны Номтой хамт Есүс Христийг гэрчилдэг бөгөөд сайн мэдээний бүрэн байдлыг агуулдаг (Езекиел 37:15–17-г үзнэ үү). Түүнчлэн Мормоны Ном Иосеф Смитийн бошиглолын дуудлага, Сэргээлтийн үнэнийг гэрчилдэг.

4.4. Сэргээлтийн нэгэн хэсэг болгон Бурхан Аароны болон Мелкизедек санваарыг сэргээлгэхээр тэнгэр элчүүдийг илгээсэн. Дараа нь Тэрээр 1830 оны 4-р сарын 6-нд Өөрийн Сүмийг шинээр зохион байгуулах удирдамжийг өгсөн. Бурхан Өөрөө Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийг зохион байгуулсан тул энэ нь “бүх дэлхийн гадаргуу дээрх цорын ганц үнэн бөгөөд амьд сүм” (С ба Г 1:30) юм.

Холбогдох эшлэлүүд: Амос 3:7; Ефес 2:19–20; Ефес 4:11–14; С ба Г 13:1; С ба Г 76:22–24; С ба Г 107:8

Холбогдох сэдвүүд: Бурхан Тэргүүтэн; Бошиглогчид ба илчлэлт

Урвалт

4.5. Уналтын улмаас Бурханы үнэн, санваарын эрх мэдэл болон Сүм хожмын үед сэргээгдэх хэрэгтэй болсон. Нэг эсвэл түүнээс олон хүн сайн мэдээний үнэнээс нүүр буруулах үед урвалт тохиолддог.

4.6. Аврагч цовдлуулж, төлөөлөгчид нь нас барсны дараа олон хүн Аврагчийн тохинуулсан үнэнээс татгалзсан юм (2 Тесалоник 2:1–3-ыг үзнэ үү). Хүмүүс сайн мэдээний зарчим, ариун судрын зарим хэсгийг гажуудуулан, үгүй хийжээ. Түүнчлэн Сүмийн зохион байгуулалт, санваарын ёслолуудыг зөвшөөрөлгүйгээр өөрчилсөн байна. Энэхүү өргөн цар хүрээтэй ёс бус үйлдлийн улмаас Их Эзэн санваарын эрх мэдэл, түлхүүрийг дэлхийгээс татан авсан юм. Хэдийгээр Бурханыг өөрт байгаа гэрлийн дагуу шүтэн биширч, залбирлынхаа хариултыг авдаг олон сайн, зөв шударга хүн байсан ч дэлхий ертөнц бошиглогчдоор дамжуулан өгөгдөг тэнгэрлэг илчлэлтгүй орхигдсон. Энэ цаг үеийг Их урвалт гэдэг.

4.7. Дэлхийн түүхэнд өөр олон урвалтын үе тохиолдсоор ирсэн.

Холбогдох сэдвүүд: Бошиглогчид ба илчлэлт; Санваар ба санваарын түлхүүрүүд; Ёслолууд ба гэрээнүүд

Сайн мэдээний эрин үеүд

4.8. Бурханы хүүхдүүд уналтын байдалд ороход Тэрээр бошиглогчдыг дуудан, бошиглогчдоороо дамжуулан сайн мэдээний адислалуудыг хүмүүст дахин шинээр өгч, хайрлаж, тусламжийн гараа сунгасан. Их Эзэн Өөрийн үнэн, санваарын эрх мэдэл, ёслолуудыг илчилдэг цаг үеийг эрин үе гэдэг. Энэ бол Их Эзэн дэлхий дээр ариун санваартай, сайн мэдээг түгээх бурханлаг итгэмжлэл хүлээсэн, ёслолуудыг гүйцэтгэх дор хаяж нэг үйлчлэгч газар дэлхий дээр байх цаг үе юм.

4.9. Эрин үеүдийг Адам, Енох, Ноа, Абрахам, Мосе, Есүс Христ болон бусад хүнээр тодорхойлдог. Их Эзэний бошиглогч Иосеф Смитээр дамжуулан эхлүүлсэн сайн мэдээний хожмын үеийн Сэргээлт нь эрин үеийн энэхүү загварын нэгэн хэсэг юм.

4.10. Эрин үе болгонд Их Эзэн болон Түүний бошиглогчид Сионыг байгуулахыг эрэлхийлдэг байсан. Сион гэж зүрх сэтгэлээрээ ариун, зөв шударга байдлаараа нэгдмэл, нэг нэгнээ халамжлан хайрладаг гэрээнд орсон хүмүүсийг хэлнэ (Мосе 7:18-ыг үзнэ үү). Түүнчлэн Сион гэж цэвэр ариун зүрх сэтгэлтэй хүмүүс амьдардаг газрыг хэлнэ.

4.11. Өнөөдөр бид сүүлийн эрин үед буюу цаг хугацааны бүрэн байдлын үед амьдарч байна. Энэ нь урвалтаар төгсгөл болохгүй цорын ганц эрин үе юм. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм эцэст нь бүх дэлхийг дүүргэн, мөнхөд орших болно (Даниел 2:44-ийг үзнэ үү).

Холбогдох сэдвүүд: Бошиглогчид ба илчлэлт; Санваар ба санваарын түлхүүрүүд; Ёслолууд ба гэрээнүүд

5. Бошиглогчид ба илчлэлт

5.1. Бошиглогч бол Бурханыг төлөөлөн ярихын тулд Түүгээр дуудагдсан хүн юм (Иеремиа 1:4–5; Амос 3:7; Иохан 15:16; С ба Г 1:37–38-ыг үзнэ үү). Бошиглогчид Есүс Христийн тухай гэрчилж, Түүний сайн мэдээг заадаг. Тэд Бурханы хүсэл, үнэн мөн чанарыг танилцуулдаг. Тэд нүглийг буруутган, үүний үр дагаврын талаар сэрэмжлүүлж, биднийг худал хуурмагаас зайлсхийхэд тусалдаг (Езекиел 3:16–17; Ефес 4:11–14-ийг үзнэ үү). Бошиглогчид заримдаа ирээдүйн үйл явдлыг бошиглодог. Бошиглогчид эрх мэдэл, илчлэлтээ Бурханаас хүлээн авдаг тул эдгээр үүрэг хариуцлагаа биелүүлдэг.

5.2. Илчлэлт бол Бурханы хүүхдүүдтэйгээ харилцдаг харилцаа юм. Ихэнх илчлэлт нь бодол, санаа, Ариун Сүнсний мэдрэмжээр дамжин ирдэг. Илчлэлт мөн үзэгдэл, зүүд, тэнгэр элчийн айлчлалаар ирдэг.

5.3. Их Эзэн мөнх бус амьдрал дахь тохинууллынхаа үеэр мөн бидний энэ үед бошиглогч, төлөөлөгч дээр тулгуурлан Өөрийн Сүмийг дахин зохион байгуулсан юм (Ефес 2:19–20-ийг үзнэ үү). Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн ерөнхийлөгч бол өнөө үед дэлхий дээр амьдарч байгаа бүх хүний Бурханы бошиглогч мөн. Бид Сүмийн ерөнхийлөгчийг бошиглогч, үзмэрч, илчлэгчийнх нь хувьд дэмжин баталдаг бөгөөд тэр бол Сүмийг бүхэлд нь удирдах илчлэлт хүлээж авдаг дэлхий дээрх цорын ганц хүн юм. Хэрэв бид Сүмийн ерөнхийлөгчийн сургаалыг итгэлтэй хүлээн авч, дуулгавартай дагавал Бурхан биднийг худал хуурмаг болон хилэнцийг ялан дийлэхэд тусалж адисална (С ба Г 21:4–6-г үзнэ үү). Бид бас Тэргүүн Зөвлөлийн зөвлөхүүд ба Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүдийг бошиглогч, үзмэрч, илчлэгч хэмээн дэмжин баталдаг билээ.

5.4. Ариун Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувд хэмээх судрууд нь эртний болон хожмын үеийн бошиглогчдоор дамжуулан өгөгдсөн илчлэлтийг агуулдаг. Бид бошиглогчдын үгсийг судалснаар үнэнээс суралцаж, удирдамж хүлээн авдаг.

5.5. Бурхан Өөрийн бүх хүүхдийг удирдан залахын тулд бошиглогчдоор дамжуулан илчлэлт өгдөг ч хувь хүмүүс өөрийн онцгой хэрэгцээ, үүрэг хариуцлага болон асуултад туслах, гэрчлэлээ хүчирхэгжүүлэх илчлэлтийг хүлээн авч чадна. Гэхдээ Их Эзэнээс хүлээн авсан сүнслэг өдөөлт нь Бурханы бошиглогчдоороо дамжуулан өгсөн илчлэлттэй хэзээ ч зөрдөггүй.

Холбогдох эшлэлүүд: Абрахам 3:22–23; Матай 16:15–19; 2 Тимот 3:15–17; 2 Нифай 32:3; С ба Г 8:2–3; С ба Г 76:22–24

Холбогдох сэдвүүд: Сүнслэг мэдлэг олж авах нь; Санваар ба санваарын түлхүүрүүд

6. Санваар ба санваарын түлхүүрүүд

6.1. Санваар бол Бурханы мөнхийн хүч ба эрх мэдэл юм. Бурхан санвааралаар дамжуулан тэнгэр, газрыг бүтээсэн бөгөөд тэдгээрийг удирддаг. Тэр энэ хүчээр дамжуулан Өөрийн хүүхдүүдийг гэтэлгэж мөн өргөмжилдөг. Санваарыг Сүмийн зохистой эрэгтэй гишүүдэд олгодог. Сайн мэдээний ёслол, гэрээнүүдээр дамжуулан санваарын адислалуудыг Бурханы бүх хүүхэд хүртэх боломжтой.

6.2. Санваарын түлхүүр нь ерөнхийлөгчийн зөвлөлийн эрх мэдэл буюу дэлхий дээр Бурханы хаант улсыг удирдан, чиглүүлэхийн тулд Бурханаас хүмүүнд өгсөн хүч юм (Матай 16:15–19-ийг үзнэ үү). Санваарын түлхүүр нь сайн мэдээний номлолыг удирдан залж, авралын ёслолуудыг хийхэд зайлшгүй шаардлагатай.

6.3. Есүс Христ Өөрийнхөө Сүмд хамааралтай санваарын бүх түлхүүрийг эзэмшдэг. Тэрээр Өөрийн төлөөлөгч бүрд дэлхий дээрх Бурханы хаант улсад хамаарах бүх түлхүүрийг олгосон. Сүмийн ерөнхийлөгч бол энэ бүх санваарын түлхүүрийг ашиглах зөвшөөрөлтэй цорын ганц хүн болно. Ариун сүмийн болон номлолын ерөнхийлөгчид мөн гадас, чуулгын ерөнхийлөгч, бишопууд томилогдсон тус тусын ажлаа тэргүүлэн, удирдах боломжийг олгогч санваарын түлхүүрүүдийг атгадаг.

6.4. Сүмд үйлчилдэг эрэгтэй, эмэгтэй хүн бүр санваарын түлхүүр бүхий хэн нэгний удирдлаган доор дуудагддаг (С ба Г 42:11-ийг үзнэ үү). Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Даллин Х.Өүкс: “Аливаа хүн алба юм уу дуудлагыг санваарын түлхүүрүүдийг атгагч нэгнээс хүлээн авснаар томилогдсон үүргүүдээ биелүүлэхэд санваарын эрх мэдлийг ашигладаг” гэж заасан (“Санваарын түлхүүрүүд ба эрх мэдэл,” *Ensign,* 2014 оны 5-р сар, 51 эсвэл *2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 68). Санваарын эрх мэдлийг зөвхөн шударга ёсны зарчмуудын дагуу ашиглах боломжтой (С ба Г 121:36, 41–42-ыг үзнэ үү).

6.5. Аароны болон Мелкизедек санваарт томилогдсон хүмүүс санваарын тангараг, гэрээнд ордог. Хэрэв тэд дуудлагаа хичээнгүйлэн гүйцэтгэж, Их Эзэнийг болон Түүний үйлчлэгчдийг итгэлтэйгээр хүлээн авбал өргөмжлөлийн адислалыг хүлээн авна. Эмэгтэйчүүд Их Эзэнтэй хийсэн гэрээндээ итгэлтэй байж чадвал өргөмжлөлийн амлагдсан адислалаас мөн адил хүртэж чадна.

Холбогдох эшлэлүүд: Иохан 15:16; Ефес 2:19–20

Холбогдох сэдвүүд: Сэргээлт; Бошиглогчид ба илчлэлт; Ёслолууд ба гэрээнүүд

Аароны санваар

6.6. Аароны санваарыг ихэвчлэн бэлтгэл санваар гэж нэрлэдэг. Аароны санваар нь "тэнгэр элчүүдийн тохинууллын хийгээд наманчлалын сайн мэдээний, мөн ... баптисмын түлхүүрүүдийг атга[даг]" (С ба Г 13:1). Энэхүү санваарыг ашиглан ариун ёслолыг бэлтгэж, адисалж, түгээдэг билээ. Аароны санваарын албан тушаалууд нь дикон, багш, прист, бишоп юм.

Мелкизедек санваар

6.7. Мелкизедек санваар нь илүү дээд буюу илүү том санваар ба "ерөнхийлөн удирдах эрхийг атгадаг бөгөөд мөн дэлхийн бүх үед сүм дэх бүх албан тушаалд сүнсний зүйлүүдэд үйлчлэх хүч болон эрх мэдэлтэй байдаг" (С ба Г 107:8). Мелкизедек санваарын ерөнхийлөгч болох Сүмийн ерөнхийлөгч нь Сүмийн бүх адислал, ёслол, гэрээ болон байгууллагыг эрх мэдлийн хүрээнд удирддаг. Энэхүү санваарыг Адамд өгсөн бөгөөд Их Эзэн Өөрийн сайн мэдээг илчлэх бүрд дэлхий дээр байсан билээ. Мелкизедек санваарын албанд ахлагч, дээд прист, патриарх, дал, төлөөлөгч орно.

Холбогдох эшлэл: Ефес 4:11–14

7. Ёслолууд ба гэрээнүүд

Ёслолууд

7.1. Ёслол гэж санваарын эрх мэдлээр гүйцэтгэдэг ариун нандин зан үйлийг хэлнэ. Бурхан Сүнсний үнэнийг заахаар, ихэвчлэн бэлгэдлээр дамжуулан заах зорилгоор ёслол бүрийг бий болгосон байна.

7.2. Зарим ёслол нь өргөмжлөлд зайлшгүй чухал бөгөөд тэдгээрийг авралын ёслол хэмээн нэрлэдэг. Бид зөвхөн авралын ёслолыг хүлээн авч, холбогдох гэрээг сахиснаар Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан авах боломжтой бүх адислалаас хүртэж чадна. Бид эдгээр авралын ёслолыг хүлээн авалгүйгээр Тэнгэрлэг Эцэгтэйгээ адилхан болох эсвэл Түүний оршихуйд мөнх амьдрахаар эргэн очих боломжгүй (С ба Г 84:20–22-ыг үзнэ үү). Авралын ёслолыг санваарын түлхүүрийг атгадаг хүмүүсийн удирдлаган доор гүйцэтгэдэг.

7.3. Сайн мэдээний хамгийн анхны авралын ёслол бол эрх мэдэлтэй нэгнээр усанд умбуулан хүртэх баптисм юм. Баптисм нь хувь хүний хувьд Есүс Христийн Сүмийн гишүүн болж, селестиел хаант улсад ороход зайлшгүй хэрэгтэй чухал ёслол мөн (Иохан 3:5-ыг үзнэ үү).

7.4. Хувь хүнийг баптисм хүртсэний дараа нэг эсвэл түүнээс олон Мелкизедек санваартан толгой дээр нь гар тавьж, Сүмийн гишүүнээр баталж, Ариун Сүнсний бэлэг өгдөг (3 Нифай 27:20-ийг үзнэ үү). Ариун Сүнсний бэлэг нь Ариун Сүнсний нөлөөнөөс ялгаатай. Хүн баптисмын өмнө Ариун Сүнсний нөлөөг мэдэрч, үнэний тухай гэрчлэл хүлээн авах боломжтой. Тэгвэл Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсныхаа дараа гэрээгээ сахиж чадсан хувь хүн Ариун Сүнстэй байнга нөхөрлөх эрхтэй болдог.

7.5. Авралын бусад ёслолд Мелкизедек санваарт томилох (эрэгтэйчүүд), ариун сүмийн хишиг хүртээх, гэрлэлтийг лацдан холбох зэрэг ёслолууд багтдаг. Түүнчлэн ариун сүмд эдгээр авралын ёслолыг нас барагсдын өмнөөс төлөөлөн гүйцэтгэж болно. Төлөөлөн хийх ёслолууд нь гагцхүү нас барсан хүн сүнсний дэлхийд тэдгээрийг хүлээн авч, холбогдох гэрээнүүдийг сахиснаар хүчин төгөлдөр болдог.

7.6. Баптисмынхаа гэрээг шинэчлэхээр ариун ёслолоос хүртэх, өвчтөнийг адислах, хүүхдийг

нэрлэх, адислах зэрэг бусад ёслол нь бидний сүнслэг өсөлт хөгжилд мөн адил чухал ач холбогдолтой.

Холбогдох эшлэлүүд: Малахи 4:5–6; Матай 16:15–19; 1 Петр 4:6; С ба Г 131:1–4

Холбогдох сэдвүүд: Бурхан Тэргүүтэн: Ариун Сүнс; Авралын төлөвлөгөө: Үхлийн дараах амьдрал; Есүс Христийн Цагаатгал; Санваар ба санваарын түлхүүрүүд

Гэрээнүүд

7.7. Гэрээ нь Бурхан, хүн хоёрын хоорондын ариун нандин тохиролцоо юм. Бурхан гэрээний нөхцөлийг тавьдаг бөгөөд бид Бурханы хийлгэхийг хүсдэг зүйлсийг хийнэ хэмээн зөвшөөрдөг. Бидний дуулгавартай байдлын хариуд Бурхан тодорхой адислал амладаг билээ (Египетээс гарсан нь 19:5–6; С ба Г 82:10-ыг үзнэ үү). Хэрэв бид гэрээгээ сахихгүй бол амлагдсан адислалыг хүлээн авахгүй.

7.8. Санваарын бүх авралын ёслолыг гэрээ дагалддаг. Жишээлбэл, бид баптисмаар дамжуулан Их Эзэнтэй гэрээ байгуулдаг Мозая 18:8–10-ыг үзнэ үү). Мелкизедек санваар хүлээн авсан эрэгтэйчүүд санваарын тангараг өргөж, гэрээ байгуулдаг. Бид ариун ёслолоос хүртсэнээр хийсэн гэрээгээ шинэчилдэг.

7.9. Бид ариун сүмд хишиг хүртэн, гэрлэлтийн лацдан холбох авралын ёслолыг хийлгэснээр дахин өөр гэрээ байгуулдаг. Бид Их Эзэний тогтоосон зохистой байдлын жишгийн дагуу амьдарснаар өөрийн биеийг ариун сүмийн ёслолд оролцон, гэрээ байгуулахад бэлддэг (Дуулал 24:3–4-ийг үзнэ үү). Ариун сүм нь үнэхээр Их Эзэний өргөө тул бид ариун сүмд орохуйц зохистой байх нь нэн чухал. Энэ бол дэлхий дээрх шүтэн бишрэх хамгийн ариун газар юм.

8. Гэрлэлт ба гэр бүл

8.1. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэрлэлтийг Бурхан заяасан бөгөөд гэр бүл нь Түүний авралын ба аз жаргалын төлөвлөгөөний төвд байдаг (Эхлэл 2:24; С ба Г 49:15-17-г үзнэ үү). Зөвхөн селестиел гэрлэлтийн гэрээ байгуулж, гэрээгээ тууштай сахиснаар эрэгтэй, эмэгтэй хүн өөрсдийн бурханлаг хийгээд мөнхийн чадавхыг гүйцэлдүүлж чадна (1 Коринт 11:11; С ба Г 131:1–4-ийг үзнэ үү).

8.2. Бурхан хүүхдүүддээ өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэ хэмээн зарлигласан байдаг (Эхлэл 1:28-ыг үзнэ үү). Үр удмаа үлдээх ариун нандин хүч нь зөвхөн хууль ёсоор гэрлэж, эхнэр нөхөр болсон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой (Эхлэл 39:9; Алма 39:9-ийг үзнэ үү). Эхнэр, нөхөр хоёр нь бие биеэ болон үр хүүхдээ хайрлан халамжлах хариуцлага хүлээнэ. Эцэг эхчүүд үр хүүхдээ хайрлан халамжилж, зөв шударгаар өсгөн хүмүүжүүлэх, бие бялдар, оюун санааных нь хэрэгцээг хангах үүрэгтэй.

8.3. Гэр бүлийн амьдрал Их Эзэн Есүс Христийн сургаал дээр үндэслэсэн байвал аз жаргалтай байх нь гарцаагүй. Эцэг хүн тэнгэрлэг загварын дагуу өрх гэрээ энэрэл хайр, зөв шударгаар тэргүүлэн, ахуй амьдралын хэрэгцээт зүйлсээр хангах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал юм. Эцэг эхчүүд энэхүү эрхэм нандин үүргээ биелүүлэхдээ харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой.

8.4. Аз жаргалын тэнгэрлэг төлөвлөгөөний дагуу гэр бүл харилцаа холбоогоо насан эцэслэснийхээ дараа ч үргэлжлүүлэх боломжтой. Гэр бүлүүдийг үүсгэж, лацдан холбож, үүрд мөнхөд өргөмжлөхийн тулд дэлхийг бүтээж, сайн мэдээг илчилсэн юм. Бид гэр бүлийн түүх болон ариун сүмийн ёслолоор дамжуулан сайн мэдээний ёслол, гэрээнүүдийг өвөг дээдсийнхээ өмнөөс хийх боломжтой (Малахи 4:5–6-г үзнэ үү).

(Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг," *Ensign,* 2010 оны 11-р сар, 129 эсвэл *2010 оны 10-р сарын Ерөнхий чуулган*-аас тохируулан авав.)

Холбогдох эшлэлүүд: Мосе 1:39; Эхлэл 1:26–27; Египетээс гарсан нь 20:3–17; Матай 16:15–19; Иохан 17:3; 1 Коринт 6:19–20; 2 Нифай 2:22–25; Мозая 2:41; Алма 41:10; С ба Г 84:20–22

Холбогдох сэдвүүд: Авралын төлөвлөгөө; Зарлигууд

9. Зарлигууд

9.1. Зарлигууд гэж өсөж хөгжин, Бурхантай адил болоход бидэнд тусалдаг, Түүний бидэнд өгсөн хууль, тавьсан шаардлагыг хэлнэ. Зарлигууд бол Бурханы биднийг хайрлах хайрын илрэл юм. Бид зарлигуудыг дагаснаар Бурханыг хэрхэн хайрладгаа харуулдаг (Иохан 14:15-ыг үзнэ үү). Зарлигийг дагаснаар үргэлж аз жаргал, Их Эзэний адислалыг авчирдаг (Мозая 2:41; Алма 41:10-ыг үзнэ үү). Бурхан хэзээ ч бидэнд Өөрийн зарлигийг гүйцэлдүүлэх замыг зэхэлгүйгээр зарлиг буулгадаггүй (1 Нифай 3:7).

9.2. Хамгийн чухал хоёр зарлиг бол "бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла. . . . Удаах нь . . . хөршөө өөрийн адил хайрла" юм (Матай 22:36–39-ийг үзнэ үү). Бид бусдыг хайрлан, тэдэнд үйлчлэхийг сонгосноор Бурханыг хайрлан, Түүнд үйлчилдэг (Мозая 2:17; Моронай 7:45, 47–48-ыг үзнэ үү).

9.3. Хүмүүнд хамгийн түрүүнд өгсөн зарлигуудын нэг бол Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих явдал юм. Бурхан хүүхдүүддээ Хүндэтгэлийн өдрөөр өөрсдийн бус Өөрийнх нь хүслийн дагуу үйлдсэнээр Өөрийг нь дээдлэхийг зарлигласан (Исаиа 58:13–14).

9.4. Арван зарлиг бол сайн мэдээний амин чухал хэсэг бөгөөд бидний өргөмжлөлд шаардлагатай мөнхийн зарчмууд билээ (Египетээс гарсан нь 20:3–17-г үзнэ үү). Их Эзэн эрт дээр үед эдгээр зарлигийг Мосед илчилсэн бөгөөд хожмын үеийн илчлэлтээр дахин өгсөн байдаг.

9.5. Бурханы зарлигт өдөр бүр залбирах, Бурханы үгийг судлах, наманчлах, ариун явдлын хуулийг сахих, аравны нэгийг бүрэн төлөх (Малахи 3:8–10), мацаг барих (Исаиа 58:6–7-г үзнэ үү), бусдыг уучлах (С ба Г 64:9–11-ийг үзнэ үү), мэргэн ухааны үгийг дагах (С ба Г 89:18–21-ийг үзнэ үү), бусдад сайн мэдээг заах (Матай 5:14–16; С ба Г 18:15–16-г үзнэ үү) зэрэг зарлигууд ордог.

Холбогдох эшлэлүүд: Эхлэл 39:9; 2 Тимот 3:15–17; Иаков 1:5–6; 2 Нифай 32:3; 2 Нифай 32:8–9; Мозая 18:8–10; Алма 39:9; 3 Нифай 18:15, 20–21; С ба Г 58:42–43; С ба Г 82:10

Холбогдох сэдвүүд: Сүнслэг мэдлэг олж авах нь; Есүс Христийн Цагаатгал: Наманчлал; Ёслолууд ба гэрээнүүд

Төгс эзэмших сургаалын судрын хэсгүүд

Төгс эзэмших сургаалын судрын хэсгүүд сэдэв, курсээр

Төгс эзэмших сургаалын судрын бүх 100 хэсгийг сэдэв болон курсээр нь жагсаав.

Сэдэв	Хуучин Гэрээ	Шинэ Гэрээ	Мормоны Ном	Сургаал ба Гэрээ болон Сүмийн түүх
Сүнслэг мэдлэг олж авах нь	Сургаалт үгс 3:5–6 Исаиа 5:20	Иохан 7:17 1 Коринт 2:5, 9–11 2 Тимот 3:15–17 Иаков 1:5–6	2 Нифай 28:30 2 Нифай 32:3 2 Нифай 32:8–9 Мозая 4:9 Ифер 12:6 Моронай 10:4–5	С ба Г 6:36 С ба Г 8:2–3 С ба Г 88:118
1. Бурхан Тэргүүтэн		Еврей 12:9	2 Нифай 26:33 3 Нифай 11:10–11 3 Нифай 12:48 3 Нифай 18:15, 20–21	С ба Г 29:10–11 С ба Г 130:22–23
2. Авралын төлөвлөгөө	Мосе 1:39 Абрахам 3:22–23 Эхлэл 1:26–27 Иошуа 24:15	Иохан 17:3 1 Коринт 6:19–20 1 Коринт 15:20–22 1 Коринт 15:40–42 1 Петр 4:6 Илчлэлт 20:12	2 Нифай 2:22–25 2 Нифай 2:27	С ба Г 76:22–24
3. Есүс Христийн Цагаатгал	Исаиа 1:18 Исаиа 53:3–5	Матай 11:28–30 Лук 24:36–39 Иаков 2:17–18	Мозая 3:19 Алма 7:11–13 Алма 34:9–10 Хиламан 5:12 Ифер 12:27	С ба Г 18:10–11 С ба Г 19:16–19 С ба Г 58:42–43
4. Сэргээлт	Мосе 7:18 Исаиа 29:13–14 Езекиел 37:15–17 Даниел 2:44	Үйлс 3:19–21 2 Тесалоник 2:1–3		Иосеф Смит—Түүх 1:15–20 С ба Г 1:30 С ба Г 135:3
5. Бошиглогчид ба илчлэлт	Иеремиа 1: 4–5 Езекиел 3:16–17 Амос 3:7	Иохан 15:16 Ефес 2:19–20 Ефес 4:11–14		С ба Г 1:37–38 С ба Г 21:4–6
6. Санваар ба санваарын түлхүүрүүд		Матай 16:15–19		С ба Г 13:1 С ба Г 42:11 С ба Г 107:8 С ба Г 121:36, 41–42
7. Ёслолууд ба гэрээнүүд	Египетээс гарсан нь 19:5–6 Дуулал 24:3–4	Иохан 3:5	Мозая 18:8–10 3 Нифай 27:20	С ба Г 82:10 С ба Г 84:20–22
8. Гэрлэлт ба гэр бүл	Эхлэл 1:28 Эхлэл 2:24 Эхлэл 39:9 Малахи 4:5–6	1 Коринт 11:11	Алма 39:9	С ба Г 49:15–17 С ба Г 131:1–4
9. Зарлигууд	Египетээс гарсан нь 20:3–17 Исаиа 58:6–7 Исаиа 58:13–14 Малахи 3:8–10	Матай 5:14–16 Матай 22:36–39 Иохан 14:15	1 Нифай 3:7 Мозая 2:17 Мозая 2:41 Алма 41:10 Моронай 7:45, 47–48	С ба Г 18:15–16 С ба Г 64:9–11 С ба Г 89:18–21

Төгс эзэмших сургаалын судрын хэсгүүд ба түлхүүр үгс

Төгс эзэмших сургаалын судрын бүх 100 хэсгийг сэдэв болон курсээр жагсаав.

Сүнслэг мэдлэг олж авах нь

Сургаалт үгс 3:5–6. “Бүх зүрхээрээ Эзэнд итгэ. Тэр чиний замыг шулуун болгоно.

Исаиа 5:20. Мууг сайн, сайныг муу гэж нэрлэгчид гаслантай яа!

Иохан 7:17. Бурханы сургаалыг мэдэхийн тулд Түүний хүслийг биелүүл.

1 Коринт 2:5, 9–11. Бид Бурханы юмсыг зөвхөн Сүнсээр дамжуулан мэдэж чадна.

2 Тимот 3:15–17. Судрууд авралд хүргэх мэргэн ухааныг та нарт өгч чадна.

Иаков 1:5–6. Хэрэв та мэргэн ухаанаар дутвал Бурханаас гуй.

2 Нифай 28:30. Бурхан бидэнд мэдлэгийг шат шатаар өгдөг.

2 Нифай 32:3. Хэрэв бид Христийн үгэн дээр найрлавал хийвэл зохих бүх зүйлээ мэдэж чадна.

2 Нифай 32:8–9. Хэрэв бид үргэлж залбирвал, Бурхан бидний үйлийг бодгальд маань золтой байж болохын тулд адислах болно.

Мозая 4:9. Бурханд итгэ, Тэр бүх мэргэн ухааныг эзэмшдэг гэдэгт итгэ.

Ифер 12:6. Итгэлийн сорилтын дараа гэрчийг хүлээн авах болно.

Моронай 10:4–5. Үнэн хүсэлтэйгээр Бурханаас асуух тэдэнд Ариун Сүнс үнэнийг илчлэх болно.

С ба Г 6:36. Санаа бодол болгондоо Христ рүү харагтун.

С ба Г 8:2–3. Ариун Сүнс бидний оюун мөн зүрх сэтгэлд ярьдаг.

С ба Г 88:118. Судлахаар мөн итгэлээр суралцахыг эрэлхийлэгтүн.

Сургаалын сэдвүүд

1. Бурхан Тэргүүтэн

Еврей 12:9. Бурхан бол бидний сүнсний Эцэг.

2 Нифай 26:33. Бурханд бүгд адил.

3 Нифай 11:10–11. Есүс Христ бүх зүйлд Эцэгийн тааллыг хүлцсэн билээ.

3 Нифай 12:48. Есүс Христ биднийг төгс болоход урьдаг.

3 Нифай 18:15, 20–21. Үргэлж сэрэмжилж мөн Есүс Христийн нэрээр залбир.

С ба Г 29:10–11. Христ сүр хүч болон алдар суутайгаар дахин ирэх болно.

С ба Г 130:22–23. Эцэг, Хүү хоёр мах хийгээд ясан биетэй.

2. Авралын төлөвлөгөө

Мосе 1:39. Бурханы ажил мөн алдар суу бол үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах явдал юм.

Абрахам 3:22–23. Абрахам төрөхөөсөө өмнө сонгогдсон байв.

Эхлэл 1:26–27. Бурхан Өөрийн дүр төрхөөр хүнийг бүтээв.

Иошуа 24:15. Та нар хэнд үйлчлэх вэ гэдгээ өнөөдөр өөрсдөө сонго.

Иохан 17:3. Бурхан, Есүс Христийг мэдэх нь мөнх амьдрал мөн.

1 Коринт 6:19–20. Та нарын бие бол ариун сүм мөн.

1 Коринт 15:20–22. Христ дотор бүгд амилуулагдах болно.

1 Коринт 15:40–42. Амилуулалтад алдар суугийн гурван зэрэглэл байдаг.

1 Петр 4:6. Сайн мэдээ нас барагсдад тунхаглагддаг.

Илчлэлт 20:12. Хүн бүр шүүгдэхээр Бурханы өмнө зогсох болно.

2 Нифай 2:22–25. Адам хүмүүн байж болохын тулд унасан.

2 Нифай 2:27. Бид сонгох эрхтэй.

С ба Г 76:22–24. Есүс Христ амьд бөгөөд дэлхийнүүдийг Бүтээгч билээ.

3. Есүс Христийн Цагаатгал

Исаиа 1:18. Хэрэв бид наманчилбал, нүглүүд маань цас шиг цагаан болно.

Исаиа 53:3–5. Есүс Христ бидний зовлонг үүрч, бидний нүглүүдийн төлөө зовсон.

Матай 11:28–30. Хэрэв бид Есүс Христэд ирэх аваас Тэр бидний ачааг хөнгөлж, бидэнд амралт өгнө.

Лук 24:36–39. Есүс Христ мах болон ясан биетэйгээр амилсан.

Иаков 2:17–18. Итгэл нь үйлсгүй бол үхмэл юм.

Мозая 3:19. Эгэл хүмүүнээ орхиж, Цагаатгалаар дамжуулан гэгээнтэн бол.

Алма 7:11–13. Есүс Христ бидний шаналлыг мэдэрч мөн нүгэл, үхлийг даван туулсан.

Алма 34:9–10. Цагаатгал хийгдэх нь зайлшгүй.

Хиламан 5:12. Христийн хадан дээр сууриа тавь.

Ифер 12:27. Аврагч сул дорой зүйлүүдийг хүчирхэг болгож чадна.

С ба Г 18:10–11. Бодгалиудын үнэ цэн агуу юм.

С ба Г 19:16–19. Бид наманчилж болохын тулд Аврагч бидний нүглүүдийн төлөө зовсон.

С ба Г 58:42–43. Бид наманчлахын тулд нүглүүдээ хүлээж мөн орхих ёстой.

4. Сэргээлт

Мосе 7:18. Сион—зөв шударга байдалд нэг зүрх сэтгэл, нэг оюунтай байх явдал.

Исаиа 29:13–14. Сэргээлт бол ер бусын ажил мөн гайхамшиг мөн.

Езекиел 37:15–17. Библи, Мормоны Ном хоёр хамтдаа нэгддэг.

Даниел 2:44. Бурханы хаант улс мөнхөд оршин тогтнох болно.

Үйлс 3:19–21. Петр Сэргээлтийн тухай бошиглов.

2 Тесалоник 2:1–3. Урьдчилан зөгнөсөн урвалт.

Иосеф Смит—Түүх 1:15–20. Анхны үзэгдлээр Их Эзэн Иосеф Смитийг бошиглогчоор дуудсан.

С ба Г 1:30. Цорын ганц үнэн бөгөөд амьд сүм.

С ба Г 135:3. Иосеф Смит бидний авралын төлөө хөдөлмөрлөсөн.

5. Бошиглогчид ба илчлэлт

Иеремиа 1:4–5. Иеремиа бошиглогч байхаар урьдчилан томилогдов.

Езекиел 3:16–17. Эзэний харуулууд Түүний сэрэмжлүүлгийг дамжуулдаг.

Амос 3:7. Бурхан Өөрийн нууцыг бошиглогчдодоо илчилдэг.

Иохан 15:16. Их Эзэн бошиглогч, төлөөлөгчдийг сонгож мөн томилов.

Ефес 2:19–20. Их Эзэний Сүм бошиглогч, төлөөлөгчдийн суурин дээр баригдсан.

Ефес 4:11–14. Бошиглогч, төлөөлөгчид гэгээнтнүүдийг төгөлдөржүүлэхэд тусалдаг.

С ба Г 1:37–38. Их Эзэн ба Түүний үйлчлэгчдийн дуу хоолой яг адил.

С ба Г 1:37–38. Бид бошиглогчийн үгийг тэвчээртэй, итгэлтэйгээр хүлээн авбал Бурхан харанхуйн хүчийг сарниулах болно.

6. Санваар ба санваарын түлхүүрүүд

Матай 16:15–19. Есүс Христ Сүмээ байгуулж, хаант улсын түлхүүрүүдийг хүртээхээ амлав.

С ба Г 13:1. Аароны санваарын түлхүүрүүд

С ба Г 42:11. Их Эзэний төлөөлөгчид эрх мэдэл бүхий хэн нэгнээр дуудагдах ёстой.

С ба Г 107:8. Мелкизедек санваарын эрх мэдэл

С ба Г 121:36, 41–42. Санваарын хүч нь аливаа хүний зөв шударга байдлаас хамаардаг.

7. Ёслолууд ба гэрээнүүд

Египетээс гарсан нь 19:5–6. Миний гэрээг сахивал та нар ариун үндэстэн болно.

Дуулал 24:3–4. Бид Их Эзэний оршихуйд зохистой байхын тулд цэвэр гар, ариун зүрхтэй байх ёстой.

Иохан 3:5. Бид Бурханы хаант улсад орохын тулд ус болон Сүнснээс төрөх ёстой.

Мозая 18:8–10. Бид баптисмаар дамжуулан Бурхантай гэрээ байгуулдаг.

3 Нифай 27:20. Баптисм хүртэж, Ариун Сүнсийг хүлээн авснаар ариусгагд.

С ба Г 82:10. Бид Их Эзэний хэлснийг хийхэд Тэрээр үүрэг хүлээдэг.

С ба Г 84:20–22. Санваарын ёслолуудад бурханлаг чанарын хүч илэрхийлэгддэг.

8. Гэрлэлт ба гэр бүл

Эхлэл 1:28. Өсөн үржиж мөн дэлхийг дүүргэгтүн.

Эхлэл 2:24. Эхнэр, нөхөр хоёр нэгэн бие болох ёстой.

Эхлэл 39:9. Иосеф уруу таталтыг эсэргүүцэв.

Малахи 4:5–6. Елиа эцгүүд болон хүүхдүүдийн зүрх сэтгэлийг эргүүлэх болно.

1 Коринт 11:11. Эрэгтэй, эмэгтэй хүн хамт байснаар л Бурханы төлөвлөгөөг биелүүлж чадна.

Алма 39:9. Нүдээрээ шунасныхаа араас дахин бүү яв.

С ба Г 49:15–17. Эрэгтэй, эмэгтэй хүний гэрлэлт Бурханаар томилогдсон.

С ба Г 131:1–4. Гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээ

9. Зарлигууд

Египетээс гарсан нь 20:3–17. Бурхан арван зарлигийг илчлэв.

Исаиа 58:6–7. Мацаг барих нь нүгэл хилэнцийн хүлгийг мултлан, буулганы оосрыг тайлан, ядуусыг халамжлахад бидэнд тусалдаг.

Исаиа 58:13–14. Хүндэтгэлийн өдөр бол Их Эзэний ариун өдөр.

Малахи 3:8–10. Аравны нэгээ төлөх нь адислалыг авчирдаг.

Матай 5:14–16. Та нарын гэрэл хүмүүсийн өмнө жишээ болон гэрэлтэг.

Матай 22:36–39 Бурхан Эзэнээ хайрла, хөршөө хайрла.

Иохан 14:15. Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь.

1 Нифай 3:7. Их Эзэн зарлигуудыг нь дуулгавартай дагах арга замыг бэлтгэдэг.

Мозая 2:17. Бид бусдад үйлчилснээр Бурханд үйлчилдэг.

Мозая 2:41. Дуулгавартай байдал нь адислал, аз жаргалыг авчирдаг.

Алма 41:10. Ёс бус явдал хэзээ ч аз жаргал байгаагүй.

Моронай 7:45, 47–48. Энэрэл бол Христийн цэвэр хайр.

С ба Г 18:15–16. Есүс Христэд бодгалиудыг авчирснаар баяр баясал ирдэг.

С ба Г 64:9–11. Бүх хүмүүнийг уучлахыг биднээс шаарддаг.

С ба Г 89:18–21. Мэргэн ухааны үгийг дагаснаар адислагдана.

Өдөр тутам уншсан судраа тэмдэглэх хүснэгт

1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2
3	3	3	3	3	3	3	3	3	3	3	3
4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4
5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5
6	6	6	6	6	6	6	6	6	6	6	6
7	7	7	7	7	7	7	7	7	7	7	7
8	8	8	8	8	8	8	8	8	8	8	8
9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9
10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10
11	11	11	11	11	11	11	11	11	11	11	11
12	12	12	12	12	12	12	12	12	12	12	12
13	13	13	13	13	13	13	13	13	13	13	13
14	14	14	14	14	14	14	14	14	14	14	14
15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15
16	16	16	16	16	16	16	16	16	16	16	16
17	17	17	17	17	17	17	17	17	17	17	17
18	18	18	18	18	18	18	18	18	18	18	18
19	19	19	19	19	19	19	19	19	19	19	19
20	20	20	20	20	20	20	20	20	20	20	20
21	21	21	21	21	21	21	21	21	21	21	21
22	22	22	22	22	22	22	22	22	22	22	22
23	23	23	23	23	23	23	23	23	23	23	23
24	24	24	24	24	24	24	24	24	24	24	24
25	25	25	25	25	25	25	25	25	25	25	25
26	26	26	26	26	26	26	26	26	26	26	26
27	27	27	27	27	27	27	27	27	27	27	27
28	28	28	28	28	28	28	28	28	28	28	28
29	(29)	29	29	29	29	29	29	29	29	29	29
30		30	30	30	30	30	30	30	30	30	30
31		31		31		31	31		31		31

ГЭР БҮЛ

ДЭЛХИЙН ДАХИНАА ӨРГӨХ ТУНХАГ

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Зөвлөл

ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМИЙН ТЭРГҮҮН ЗӨВЛӨЛ БА АРВАНХОЁР ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙНХӨН бид эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хооронд гэрлэлт нь Бурханаас заяасан бөгөөд гэр бүл нь Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдгийг чин сэтгэлээсээ тунхаглаж байна.

БҮХ ХҮН ТӨРӨЛХТӨН эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг Бурхан, өөрийн дүр төрхөөр бүтээсэн. Хүн бүр Тэнгэрлэг Эцэг Эхийн хайртай сүнслэг охин, хүү нь бөгөөд хүн бүр бурханлиг шинж чанар, хувь тавилантай юм. Хүйс бол хувь хүний мөнх бус байдлын өмнөх, мөнх бус болон мөнхийн амьдралын тодорхойолт ба зорилгын салшгүй шинж чанар юм.

МӨНХ БУС БАЙДЛЫН ӨМНӨХ АМЬДРАЛД сүнслэг охид хөвгүүд Бурханыг Мөнхийн Эцэг хэмээн мэдэж, биширч, мөнхийн амьдралыг өвлөн авах тэнгэрлэг хувь заяагаа бүрэн дүүрэн ухааран ойлгож төгс төгөлдөр болон хөгжин дэвшихийн тулд бие махбодтой болж энэ дэлхийд амьдрах тухай Түүний төлөвлөгөөг хүлээн зөвшөөрсөн юм. Аз жаргалын тэнгэрлэг төлөвлөгөө нь насан эцэслэсний дараа ч гэр бүлийн холбоог мөнхжүүлдэг. Ариун сүмийн ёслолууд болон гэрээнүүд нь хувь хүн Бурханы оршихуйд эргэн очих, гэр бүлүүд мөнхөд нэгдэх боломжийг олгодог.

БУРХАНЫ АДАМ, ЕВА хоёрт өгсөн анхны зарлиг нь эхнэр нөхрийн хувьд эцэг эх болох талаар байлаа. Өдгөө бид Бурханы хүүхдүүддээ "өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэ" хэмээсэн зарлиг нь хүчин төгөлдөр байгаагаа тунхаглаж байна. Түүнчлэн "үр удмаа үлдээх энэхүү нандин хүч нь зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эхнэр нөхөр болон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой" хэмээсэн Бурханы зарлигийг тунхаглаж байна.

МӨНХ БУС АМЬДРАЛЫН арга зам нь тэнгэрээс тогтоогдсон гэдгийг бид тунхагладаг. Бурханы мөнхийн төлөвлөгөөн дэх амьдралын цэвэр ариун байдал, түүний ач холбогдлын чухлыг бид батлан хэлж байна.

ЭХНЭР НӨХӨР хоёр нь бие биеэ болон үр хүүхдээ хайрлан халамжлах хариуцлага хүлээнэ. "Үр хүүхэд бол Их Эзэний өв юм" (Дуулал 127:3). Эцэг эхчүүд нь хүүхдүүдээ хайр, зөв шударга байдлаар өсгөн хүмүүжүүлж бие бялдар болон оюун санааных нь хэрэгцээг хангаж, бие биеэ хайрлан, үйлчилж, Бурханы зарлигуудыг дагаж, хаана ч амьдарсан хуулиа хүндэтгэн сахидаг иргэд байхыг зааж сургах нандин үүрэгтэй юм. Эхнэр нөхөр, эцэг эхчүүд үүргээ хэрхэн биелүүлснээрээ Бурханы өмнө хариуцлага хүлээнэ.

ГЭР БҮЛ Бурханаас заяагддаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэр бүл болох нь Түүний мөнхийн төлөвлөгөөний зайлшгүй нэг хэсэг юм. Хүүхдүүд нь гэр бүлд төрж, гэрлэлтийн тангарагаа үнэнчээр сахидаг эцэг эхээр өсгүүлэх эрхтэй. Их Эзэн Есүс Христийн сургаал дээр үндэслэсэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно. Аз жаргалтай гэрлэлт болон гэр бүлүүд нь итгэл, залбирал, наманчлал, өршөөл, хүндэтгэл, хайр, өрөвч сэтгэл, ажил хөдөлмөр ба гэр бүлээрээ үр бүтээлтэй үйл ажиллагаа зохиох зарчмуудыг баримтлан амьдарна. Тэнгэрийн загвараар эцэг нь гэр бүлээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, хэрэгцээт зүйлсээр нь хангаж, хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал юм. Энэхүү нандин үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой. Хувь хүн тахир дутуу болох, нас нөгчих болон бусад нөхцөл байдалд зайлшгүй дасан зохицох шаардлага гарч болно. Төрөл төрөгсөддөө шаардлагатай үед туслан дэмжих ёстой.

АРИУН ЯВДЛЫН ГЭРЭЭГЭЭ ЗӨРЧИН, хань ижил, үр хүүхэдтэйгээ зүй бусаар харьцсан, гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй хувь хүн хожмын нэг өдөр Бурханы өмнө өчиг мэдүүлэх болохыг бид анхааруулж байна. Түүнчлэн гэр бүлээ сарниулбал эрт эдүгээгийн бошиглогчдын зөгнөн хэлснээр хувь хүн, нийтэм, улс үндэстнүүдэд гай гамшиг авчрах болно гэдгийг бид сануулж байна.

ИТГЭЛ ХҮЛЭЭСЭН иргэд, төрийн албан хаагч та бүхнийг нийтмийн үндсэн нэгж болох гэр бүлийг бэхжүүлэн авч явах арга замуудыг ямагт хэрэгжүүлэгтүн хэмээн уриалан дуудаж байна.

Энэхүү тунхгийг 1995 оны 9 сарын 23-нд Юта мужийн Солт Лейк хотноо болсон Ерөнхий Нийгмийн Халамжийн бүлгийн чуулган дээр Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли захиасынхаа нэгэн хэсэг болгон уншсан юм.

Шашны институт, семинарын зорилго

Бидний зорилго бол өсвөр үеийнхэн болон залуучуудад Есүс Христийн сургаал, Цагаатгалыг ойлгон, тэдгээрт найдаж, ариун сүмийн адислалыг хүртэхүйц зохистой байж, өөрсдийгөө болон гэр бүлээ мөн бусдыг Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдрах мөнх амьдралд бэлтгэхэд туслах явдал юм.

Эдгээр зорилтод хүрэхийн тулд шашны семинар, институтийн багш, суралцагчдыг сайн мэдээг заах, судлах үндсэн зарчмыг амьдралдаа онцгойлон хэрэгжүүлэхэд дэмжих ёстой.

Багш, суралцагчид дараах зүйлсийг хийвэл зохино. Үүнд:

- Сүнсээр заах мөн суралцах
- Хайр, хүндэтгэл, зорилго бүхий суралцах орчинг бүрдүүлэх
- Судраас өдөр бүр судалж, хичээлийн гарын авлага, материалыг унших
- Судрын болон бошиглогчдын үгсийн хам сэдэв, агуулгыг ойлгох
- Сайн мэдээний сургаал, зарчмуудын үнэн ба ач холбогдлыг олж тогтоон, ойлгож, мэдэрч, амьдралдаа хэрэгжүүлэх
- Сайн мэдээний сургаал, зарчмуудыг тайлбарлан, хуваалцаж, гэрчлэх
- Төгс эзэмших сургаалыг эзэмших зэрэг юм.

ШАШНЫ ИНСТИТУТ
БА СЕМИНАР

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

© 2016, 2017 Intellectual Reserve, Inc. All rights reserved.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв. Англи эхийн зөвшөөрөл: 10/17.
Орчуулгын зөвшөөрөл: 10/17. *Study Journal*-ын орчуулга. Mongolian. 13256 363
Нүүр хуудсанд: *Саймон Дюви,* Гэрэл ба үнэн

MONGOLIAN
4 02132 56363 5
13256 363